



ЯПОН ХЭЛНЭЭС МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛАГДСАН
БҮТЭЭЛИЙН ТОЙМ

(Overview of Mongolian translations from Japanese)

П.Энхжаргал²⁴

Д.Майсүлд²⁵

Abstract: Over the past five decades, Mongolia has developed a growing number of professionals proficient in the Japanese language. As bilateral relations between Mongolia and Japan have expanded across political, economic, cultural, and educational spheres, the volume of translated Japanese literature and texts from various specialized domains into Mongolian has increased substantially. This study aims to systematically document, classify, and examine the corpus of Japanese-to-Mongolian translations across historical periods and thematic domains. Drawing upon foundational theories in translation studies, the research not only offers a quantitative overview but also seeks to elucidate key trends and shifts in the evolving landscape of literary and non-literary translation between the two languages.

Түлхүүр үг: орчуулга судлал, орчуулгын төрөл, уран зохиолын орчуулга, мэргэжлийн орчуулга

Удиртгал

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын хоорондын соёл, боловсрол, эдийн засгийн харилцаа эрчимтэй өргөжин хөгжиж буй энэ цаг үед орчуулгын үүрэг, ач холбогдол урьд өмнөхөөс илүүтэй чухалчлагдаж байна. Тухайлбал, Япон болон Монгол улсын харилцаа олон салбарт гүнзгийрч, хоёр орны соёлын солилцоо өргөжихийн хэрээр япон хэлнээс монгол хэл рүү, мөн монгол хэлнээс япон хэл рүү орчуулсан уран зохиол, эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн чиглэлийн бүтээлүүдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь хоёр орны харилцан ойлголцол, соёлын уялдаа холбоог гүнзгийрүүлэхэд чухал үүрэгтэй. Монгол улсад япон хэлнээс орчуулагдсан бүтээлүүд нь зөвхөн уран зохиолын хүрээнд бус, түүх, гүн ухаан, шашин, нийгэм, техник технологи зэрэг олон талт сэдвийг хамарч эхэлжээ. Монгол хэлнээс орчуулагдсан япон бүтээлүүдийн тоо харьцангуй нэмэгдэж байгаа хэдий ч тэдгээрийг тоймлон судалсан нь төдийлөн их биш байна. Энэ нь уг чиглэлээр судалгааны хэрэгцээ шаардлага байгааг илтгэх нэг илрэл бөгөөд япон хэлнээс орчуулсан бүтээлүүдийн төрөл зүйлийг нэгтгэн тоймлох нь зөвхөн орчуулга судлалын салбарт төдийгүй хэл шинжлэл, соёл судлал, харьцуулсан уран зохиолын хүрээнд ч үнэ цэнтэй юм. Тус өгүүллийн зорилго

²⁴ Доктор Ph.D, Монгол Улсын Их Сургууль, Ази судлалын тэнхим

²⁵ Доктор Ph.D, Монгол Улсын Их Сургууль, Ази судлалын тэнхим

нь япон хэлнээс монгол хэлнээ орчуулагдсан бүтээлийг бүртгэн, орчуулгын онолын суурь бүтээлүүдэд тулгуурлан ангилж, тэдгээрийн төрөл, чиг хандлагыг тодруулах юм.

Судлагдсан байдал:

Япон хэлнээс монгол хэл рүү орчуулагдсан бүтээлийн тойм судалгаа нь уран зохиолын орчуулгыг голчлон анхаарч иржээ. Тухайлбал, С.Долгор (2005) “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм” өгүүлэл, Д.Мандах (2010) “Япон уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага” нэг сэдэвт бүтээл, С.Долгор нар (2016) “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм /2007-2016/” өгүүлэл, А.Дэлгэрмаа нар (2016) “Монголд Японы уран зохиолыг орчуулж буй өнөөгийн байдал, тулгарч буй асуудал” зэргийг дурдаж болно. Энд дурдсан уран зохиолын орчуулгын судалгаа нь 1950-аад оны үеэс гадаад хэлээр дамжуулан орчуулж ирсэн японы уран зохиолоос эхэлж буй бүтээлийг 2016 он хүртэл бүртгэн, тухайн бүтээлийг орчуулсан хэл, төрөл зүйл зэргээр ангилсан байна. Тухайлбал, А.Дэлгэрмаа нар (2016) Японы уран зохиолыг монгол хэлэнд орчуулагдсан тоймыг 1953-1980 он, 1980 оноос өнөөг хүртэлх үед хуваан авч үзэж, орчуулсан орчуулгын төрөл зүйл, орчуулсан хэлээр нь нарийвчлан товчоолжээ²⁶.

Бид “Япон судлалын ном зүй” төслийн хүрээнд япон хэлнээс монгол хэлэнд орчуулсан төрөл бүрийн орчуулгын 1000 орчим ном, бүтээлийг дээр дурдсан судалгааны бүтээл болон номын сангийн каталог, хэвлэлийн газрын мэдээлэл, орчуулагч судлаачдын бүтээлийн жагсаалт зэрэгт тулгуурлан цуглуулж бүртгэсэн болно. Уран зохиолын орчуулгын хувьд нэгэнт 2016 он хүртэл тойм судалгаа хийгдсэн тул эл өгүүлэлд шинээр нэмж бүртгэсэн 2017-2024 онд орчуулагдсан бүтээлд анализ хийв. Харин уран зохиолоос бусад бүтээл буюу мэдээллийн (тусгай) - шинжлэх ухаан, техник, албан баримт бичиг, нийгэм-улс төр зэрэг нийгмийн амьдралын бүхий л салбарт хамаарах бүтээлийг орчуулгын онол судлаач эрдэмтдийн онол, ангилал, түүнчлэн шинжлэх ухааны ангилал зэрэгт тулгуурлан ангилж дүн шинжилгээ хийв.

1. Уран зохиолын орчуулга (2017-2024)


Орчуулгын бүтээлийг тоймлон судалсан судлаачдын бүтээлээс үзэхэд Монгол улсад 1953 оноос 1980 оны үед орчуулсан нийт зохиолын 97% нь орос хэлнээс дам орчуулсан зохиол байгаа бөгөөд тэдгээрийг Б.Явуухулан, Ч.Чимэд, Ж.Лхагва, М.Цэндэндорж, О.Цэндсүрэн, Х.Мэргэн нарын тухайн үеийн нэрт зохиолч, орчуулагчид орчуулсан бол Д.Батаа, Д.Алмаас, Т.Чойжилжав нар эх хэлнээс нь орчуулж²⁷ байсан онцлогтой байсан байна. 1980 оноос 2016 он хүртэл 300 орчим уран зохиолын бүтээл орчуулагдсан бөгөөд 2006 оноос 2016 оны хооронд 10 жилийн хугацаанд тууж, роман зэрэг томоохон хэмжээний зохиолын орчуулгын ажил чамгүй хийгдсэн байна²⁸.

Харин бидний цуглуулсан баримтаар 2017-2024 оны 8 жилийн хугацаанд хооронд нийт 84 уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан бөгөөд эдгээрийг яруу найраг, эсээ, тууж, роман, үлгэр, зурагт ном гэж ангилан үзэв (Диаграмм 1).

²⁶ А.Дэлгэрмаа, Ц.Онон “Монголд Японы уран зохиолыг орчуулж буй өнөөгийн байдал, тулгарч буй асуудал”, УБ.,2016, 125-127 тал

²⁷ С.Долгор нар “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм /2007-2016/”, 143 тал

²⁸ Дээрх бүтээл, 146 тал



Диаграмм 1. “Уран зохиолын орчуулгын төрлөөр”

2017-2024 оны хооронд орчуулсан бүтээлийн 50 орчим хувийг өгүүллэг, тууж, роман эзэлж байгаа бөгөөд сүүлийн үед яруу найргийн орчуулга цөөн хийгдэх болсон байна. Тухайлбал, 1980-2016 оны хооронд яруу найргийн орчуулга 49 хувийг эзэлж байсан бол 2017-2024 оны хооронд 1 хувь болж буурчээ. Харин сүүлийн үед хүүхдэд зориулсан зурагт номыг харьцангуй их орчуулсан онцлог ажиглагдав.

Уран зохиолын бүтээлийг орчуулсан байдлыг авч үзэхэд өгүүллэгийн хувьд О.Жаргалсайхан орчуулагчийн бүтээл нэлээд хувийг эзэлж байна. Тэрээр Дазаи Осамү, Акүтагава Рюүносүкэ, Шибарёотароо нарын бүтээлийг монгол хэлнээ орчуулж уншигчдын хүртээл болгожээ. Мөн энэ хугацаанд 18 роман орчуулжээ. Үргэлжилсэн үгийн бүтээлийн хувьд Д.Чимгээ, О.Жаргалсайхан, Ц.Онон, Ж.Оюунцэцэг, Г.Сугирагчаа нарын орчуулагчийн бүтээл голлож байгаа бөгөөд Оз Кэнзабүроо, Казүо Ишигүро, Мүраками Харүки, Мүрасаки Шикибү, Эдогава Рампо зэрэг зохиолчдын бүтээлийг орчуулсан байна. Орчуулгын бүтээлийн, ялангуяа романы орчуулгын эрхийг Монсудар хэвлэлийн газар эзэмшиж, эрхлэн гаргаж буйгаараа онцлог юм.

2. Уран зохиолын бус орчуулга

Уран зохиолын бус орчуулгын бүтээлийг ангилахдаа бид Д.Долгорсүрэн, Д.Гүн-Үйлс, В.Н.Комиссаров, Roda P.Roberts зэрэг судлаачдын онолын бүтээлийг тулгуур болгов.

Д.Долгорсүрэн (2020) орчуулгын төрөл зүйлийг ямар чиглэлийн, аль салбарын орчуулга болохоос нь хамаарч тодорхойлдог гэж үзээд,

- Нийгэм, улс төрийн зохиол бүтээлийн орчуулга
- Сонин сэтгүүлийн өгүүлэл, нийтлэл, мэдээллийн хэрэглэгдэхүүний орчуулга
- Шинжлэх ухаан техникийн зохиол бүтээлийн орчуулга
- Уран зохиолын орчуулга
- Дипломат албан бичиг баримт ба хууль эрхийн актын орчуулга²⁹ гэж хуваажээ.

Харин В.Н.Комиссаров “Орчуулгын төрлүүдийг орчуулагдаж буй сэдвийн шинж чанар, орчуулгын үйл явц дахь орчуулагчийн хэл ярианы үйлдлийн шинж төлөвөөр нь хоёр ангилдаг байна.

²⁹ Д.Долгорсүрэн “Дипломат баримт бичгийн орчуулга” Орчуулгазүй – VIII, УБ.,2020

Эхнийх нь эх сэдвийн төрөл зүйл, найруулга зүйн онцлогтой, хоёр дахь нь бичгийн ба аман орчуулга дахь хэл ярианы үйлдлийн сэтгэц-хэл шинжлэлийн онцлогтой холбоотой гэх бөгөөд төрөл зүйл-найруулга зүйн ангилал нь эх сэдвийн төрөл зүйл-найруулга зүйн онцлогоос хамааран *утга зохиолын орчуулга, мэдээллийн (тусгай) орчуулга* гэсэн чиг үүрэгтэй хоёр төрлийг нөхцөлдүүлдэг. ... Мэдээллийн орчуулга гэдэг нь *унишигчдад уран сайхан-гоо зүйн нөлөө үзүүлэх биш, харин ямар нэгэн бодит баримтыг мэдээлэх үндсэн чиг үүрэг бүхий сэдвийн орчуулга юм*. Ийм сэдэвт шинжлэх ухаан, техник, албан баримт бичиг, нийгэм-улс төр, ахуйн зэрэг нийгмийн амьдралын бүхий л салбарт хамаарах материалууд багтана³⁰ гэжээ.

Түүнчлэн, Д.Гүн-Үйлс орчуулгыг 1.нийтлэлийн, 2.мэргэжлийн, 3.уран зохиолын орчуулга гэж ангилж болно гэсэн байдаг. Нийтлэлийн орчуулгад сонины өгүүлэл, сурвалжилгаас эхлээд зар, мэдээ, нийтлэл сэлтийн орчуулгыг хамруулж болно. Мэргэжлийн орчуулгад улс төр, эдийн засаг, хими, биологи, анагаах ухаан гээд хүмүүнлэгийн болон байгалийн ухааны бүх нарийн мэргэжлийн сэдвээр хийх орчуулгыг хамруулна³¹ гэсэн байна.

Roda P.Roberts "*Towards a Typology of Translations*" хэмээх өгүүлэлдээ орчуулгыг хоёр үндсэн чиглэлээр ангилах санал дэвшүүлсэн бөгөөд сэдвийн хүрээгээр нь шинжлэх ухаан-технологи, нийгэм-улс төр, эдийн засаг гэж хуваасан байна. Мөн шинжлэх ухаан, технологийн орчуулгад физик, хими, биологи, инженерчлэл, компьютер, математик, механик, архитектур гэсэн дэд сэдэв, нийгэм, эдийн засаг, улс төрийн орчуулгад эдийн засаг, нийгмийн ухаан, улс төр, олон улсын харилцаа, хууль эрх зүй, бизнес, санхүү, захиргаа гэсэн дэд сэдвүүдийг оруулсан байна.

Дээрх судлаачдын бүтээл нь мэргэжлийн буюу шинжлэх ухааны орчуулгын ангиллыг товч дурдаад нарийвчлан тодорхойлсон байдал ажиглагдсангүй. Иймд бид уран зохиолоос бусад орчуулгын ангиллыг хийхдээ нэгэнт шинжлэх ухааны орчуулга гэдэг категорид багтаах юм бол ЮНЕСКО-гийн Шинжлэх ухааны ангиллын системд тулгуурлах боломжтой гэж үзсэн болно. ЮНЕСКО-оос шинжлэх ухааныг дараах 6 салбар болгон шинжлэх ухааныг ангилсан байна. Энэ нь:

1. Байгалийн шинжлэх ухаан (Natural Sciences) Үүнд: математик, компьютерын шинжлэх ухаан, физик, хими, амьд биетийн шинжлэх ухаан (биологи, экологи гэх мэт), газар зүй, геологи
2. Инженер, технологи (Engineering and Technology) үүнд: инженерчлэл (цахилгаан, барилга, механик гэх мэт) материал судлал, нано-технолог, байгаль орчны инженерчлэл, программ хангамж, хиймэл оюун ухаан зэргийг оруулсан
3. Анагаах ухаан, эрүүл мэнд (Medical and Health Sciences) салбарт анагаах ухаан, нийтийн эрүүл мэнд, сувилахуй, эмийн судалгаа, шүдний анагаах ухаан зэргийг багтаасан.
4. Хөдөө аж ахуй (Agricultural Sciences) мал эмнэлэг, ургамал, малын генетик, хүнсний технологи, ойн аж ахуй, усны аж ахуй, загасны аж ахуй зэрэг дэд бүлэгтэй.
5. Нийгмийн ухаан (Social Sciences) эдийн засаг, сэтгэл судлал, нийгэм судлал, хууль, улс төр судлал, боловсрол судлал зэргийг оруулсан.
6. Хүмүүнлэгийн ухаан (Humanities) салбарт түүх, хэл шинжлэл, утга зохиол, шашин судлал, урлаг судлал, философи зэрэг дэд салбартай байна.


³⁰ В.Н.Комиссаров, Орчуулгын онол, УБ.,2008, 79 тал

³¹ Д.Гүн-Үйлс, "Орчуулга, найруулга зүй", УБ.,2008, 5, 6 тал

2. Мэдээллийн буюу тусгай орчуулгын бүтээлийн тойм

1990 оноос 2024 оны хооронд шинжлэх ухаан, техникийн болон нийгэм, эдийн засаг, улс төрийн сэдэвт 222 бүтээлийг япон хэлнээс орчуулжээ. Эдгээр бүтээлийг байгалийн шинжлэх ухаан, инженер технологи, анагаах ухаан, эрүүл мэнд, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухаан гэсэн салбарт хуваан авч үзлээ. Салбар тус бүрийн хувь хэмжээг диаграммаар үзүүлэв (Диаграмм 2).

Диаграмм 2. “Орчуулгын төрөл шинжлэх ухааны салбараар”



2.1. Байгалийн шинжлэх ухааны салбарын орчуулга

Байгалийн шинжлэх ухааны сурах бичгийн орчуулга 2005 онд анх эхэлсэн бөгөөд математик, физик, компьютерын шинжлэх ухааны нийт 8 бүтээлийг орчуулсан байна. 2018-2021 оны хооронд нийт бүтээлийн 90 орчим хувь нь хийгджээ. Ерөнхийдөө Япон маягийн коосэн сургалтын байгууллага бий болж, зарим сурах бичгийг орчуулах болсонтой холбоотой байна.

2.2. Инженер технологийн салбарын орчуулга

Энэ салбарын орчуулга маш бага хийгдэж ирсэн бөгөөд 2007 онд Нано технологи нэртэй бүтээлийг монгол хэлнээ орчуулжээ.

2.3. Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын орчуулга

1991 онд Т.Намикоши “Японы шиацу хэмээх даран барих засал” нэрт жижиг гарын авлага орчуулагдсан бөгөөд түүнээс хойш 2009 он хүртэл энэ салбарын орчуулга хийгдээгүй байна. 2009 оноос эхлэн жил бүр нэг орчим бүтээл орчуулагдах болж, харин 2014 оноос эхлэн зөвхөн эрүүл мэндийн төдий бус анагаахын шинжлэх ухааны сурах бичиг, гарын авлага, атлас зэрэг орчуулагдах болжээ. Мөн сувилахуйн салбарын ажиллах хүчин гадаадаас авах болсонтой холбоотой энэ чиглэлийн мэргэжлийн стандарт, гарын авлагыг ч монгол хэл рүү орчуулах болсон байна. 1991 онд 1 бүтээл, 2009 оноос хойш 18 бүтээл орчуулагдсан байна. Эдгээр орчуулгын 56 хувийг буюу анагаах ухааны орчуулга эзэлж байгаа бөгөөд бусад салбартай харьцуулахад харьцангуй их байна. Түүнчлэн Японы уламжлалт эмчилгээний болон орчин үеийн эмнэлгийн шинэ арга техникүүдийг

танилцуулсан орчуулга нэлээд хийгджээ. Эрүүл мэндийн тухайд турах арга, эрүүл зөв хооллолт, өвдсөн үеийн зөвлөгөө зэрэг сэдвүүд голлосон байна.

2.4. Нийгмийн ухааны салбарын орчуулга

1992 оноос Японы бизнесийн талаарх сэдвийг сонирхон орчуулж эхэлжээ. Тухайлбал, 1992 онд Морита Акиогийн “"Sony" компанийн тухай Японд үйлдвэрлэв” бүтээл, 1995 онд Инохара Хидэогийн “Удирдлагын ухаан, хүн хүчний нөөцийн хөгжил” бүтээлийг, 1997 онд Морита Акиогийн “Японд үйлдвэрлэв: Бидний туршлагажсан олон улсын стратеги” бүтээлийг тус тус орчуулсан байна. Гэхдээ эдийн засгийн салбарын орчуулга түүнээс хойш бараг хийгдээгүй бөгөөд 2010 онд ЖАЙКА-аас “Япон улсын татварын дэлгэрэнгүй гарын авлага 2010”-ыг орчуулан гаргажээ. Хууль, эрх зүйн салбарын тухайд 2011 онд Япон улсын үндсэн хууль болон 2018 онд “Япон улсын иргэний хууль” орчуулагджээ. Нийгмийн ухааны салбарын тухайд, эдийн засаг, нийгэм, хууль, улс төр, бизнес, олон улсын харилцаа, боловсрол судлал, хүүхэд хүмүүжлийн чиглэлээр 65 бүтээлийг орчуулж нийтийн хүртээл болгосон байна. Сүүлийн үед боловсрол судлал, түүний дотроос хүүхдийн хүмүүжил, хувь хүний хөгжлийн чиглэлийн ном бүтээл, гарын авлага зэргийг илүүтэй орчуулсан байна. Түүнчлэн хувь хүний хөгжлийн талаарх ном бүтээлүүд япон хэлнээс цөөнгүй орчуулагдсан байгаа нь Монголд энэ чиглэлийн эрэлт хэрэгцээ их байгааг илтгэж байна. Нийгмийн ухааны чиглэлээр нийт 100 гаруй бүтээл орчуулагдсан байна.

2.5. Хүмүүнлэгийн ухааны салбарын орчуулга

1974 онд Японы алдарт волейболчин эмэгтэй Хирофүми Даймацүгийн “Намайг дууриагтун” бүтээлийг орчуулснаар энэ салбарын орчуулга эхэлжээ. Үүний дараа 1988 онд Үшижима Ясучикагийн “Номонханы байлдааны бүрэн түүх” бүтээл япон судлаач Б.Сэржавын орчуулгаар гарчээ. Түүнээс хойш орон судлал, түүх, философи, шашин судлал, хэл шинжлэлийн чиглэлээр 90 орчим бүтээл гарсан байна. Он цагийн хувьд 2010 оноос хойш энэ салбарын орчуулга идэвхжиж, жилд багадаа 5-аас дээш бүтээл орчуулагдсан байна. Мөн Японы түүх, орон судлалын талаарх бүтээлүүд багагүй орчуулагджээ. Түүнчлэн шашин судлалын чиглэлийн орчуулгад Японы буддын шашны ойлголт, философийн сэдэв дийлэнх хувийг эзэлж байгаагаараа онцлог байв. Хэл шинжлэлийн чиглэлд япон хэлний сурах бичгийн орчуулга хийгээд нэрт монголч эрдэмтдийн монгол хэлний талаарх эрдэм шинжилгээний өгүүлэл дийлэнх хувийг эзэлж байна.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд, Монголд Японы уран зохиолын орчуулга орчуулгын хамгийн их хувийг эзэлж иржээ. Харин сүүлийн үед бусад шинжлэх ухааны салбарын орчуулга ч хийгдэх болсон байна. Ялангуяа, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын орчуулга бүх салбарыг хамарчээ. Харин байгалийн ухаан хийгээд инженер технологийн салбарын орчуулга бага хийгээд хөдөө аж ахуйн чиглэлийн орчуулга бидний бүртгэлд ороогүй байна. Хоёр орны харилцаа олон салбарт хөгжиж байгаа хэдий ч тухайн салбарын мэдлэг, мэдээллийг өргөн хүрээнд орчуулах хэрэгцээ шаардлага хязгаарлагдмал, харин нийгэм, олон нийтэд чиглэсэн уран зохиол, хүүхдийн хүмүүжил, философи, сэтгэл судлал, ялангуяа хувь хүний хөгжилд чиглэсэн бүтээлийн хэрэгцээ, шаардлагыг даган энэ чиглэлийн орчуулга илүүтэй хийгдэж байгаа нь ажиглагдав.

Ном зүй

- Baker, M., & Saldanha, G. (Eds.). (2020). Routledge encyclopedia of translation studies (2nd ed.). Routledge.
- Gambier, Y., & van Doorslaer, L. (Eds.). (2021). Handbook of translation studies (Vol. 4). John Benjamins Publishing Company.
- Munday, J. (2021). Introducing translation studies: Theories and applications (5th ed.). Routledge.
- Гүн-Үйлс Д. (2008) “Орчуулга, найруулга зүй”, УБ
- Долгор С., Онон Ц. (2016) “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм /2007-2016/”
- Долгорсүрэн Д. (2020) “Дипломат баримт бичгийн орчуулга” Орчуулгазүй–VIII, УБ
- Дэлгэрмаа А., Онон Ц. (2016) “Монголд Японы уран зохиолыг орчуулж буй өнөөгийн байдал, тулгарч буй асуудал”, УБ
- Комиссаров В.Н., (2008) Орчуулгын онол, УБ